

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН “ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 02

Өлгий хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ийн өдрийн 377 тоот тогтоол, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 14:30 цагаас компанийн хурлын зааланд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

2.1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

2.2. Компанийн 2023 оны жилийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулах;

2.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

2.4. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийн талаарх ТУЗ-ийн мэдээллийг хэлэлцэж батлах

2.5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төсвийг батлах

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай.

Комиссын даргаар: Компанийн Гүйцэтгэх захирал М.Тилеуберди, гишүүдэд: ТУЗ-ийн гишүүд А.Бейбит, У.Харашаш.

4. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст даалгах нь:

4.1. Ээлжит хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд хүргэх зар мэдээг 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн дотор олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, хөрөнгийн биржийн цахим хуудсаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх арга хэмжээ авах.

4.2. Энэ тогтоолын 4.1-д заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын

сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх.

4.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг холбогдох баримт бичгийн хамт Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д 2024 оны 03 дугаар сарын 18-ны дотор хүргүүлэх.

4.4.Хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх “Таван богд ҮЦК” ХХК-тай гэрээ байгуулж, уг гэрээний дагуу зуучлуулан зохион байгуулах;

4.5 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал тэдгээрийн танилцуулга, гарах шийдвэрийн төсөл, санал авах, хуудсыг үнэт цасны брокер дилерийн компанийд хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2023 оны 3 дугаар сарын 25-ний дотор багтаан хүргүүлэх;

5.5 Хурлаас хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийг дуустал 09-13, 14-17 цагт компанийн хурлын зааланд танилцуулж саналын хуудсаар санал авах ажлыг зохион байгуулах.

5.Хурал зарласан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд дор дурьдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

5.1.Компанийн жилийн санхүүгийн тайлан тэнцэл

5.2. Санхүүгийн жилийн тайлангийн талаар Аудиторын дүгнэлт

5.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн тухай танилцуулага

5.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлуулах

5.5 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох бусад мэдээлэл

6.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэ тогтоолын хавсралтаар баталсугай.

7.Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ний өдрөөр тогтоосугай.

8.Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.

9.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга А.Маненийг сонгосугай.

10.Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар О.Адилбек, гишүүнээр Ш.Майраш, Ж.Сериюжан нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.МАНЕН